

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН КОМИСС**

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ОРОЛЦОГЧ УЛС  
ХООРОНД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААГ ИДЭВХЖҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ  
ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР**

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР**

# **АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ОРОЛЦОГЧ УЛС ХООРОНД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААГ ИДЭВХЖҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР**

(цаашид “энэхүү хэлэлцээр” гэх)

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Засгийн газар, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-ийн Оролцогч улсууд (цаашид “Оролцогч улс” гэх);

Үйлчилгээний худалдааны ач холбогдол Оролцогч улсын хувьд нэмэгдэж буйг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;**

Хамтын зүтгэлээр үйлчилгээний худалдааг чөлөөлөх, АНДХХ-ийн хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг идэвхжүүлэх замаар Оролцогч бүх улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг тогтворжуулахын чухлыг **НОТОЛЖ;**

Оролцогч улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа нь тэдний хооронд үйлчилгээний худалдааг дэмжин, бэхжүүлэх зорилго бүхий үйлчилгээний худалдааг чөлөөтэй эрхлэх орчин бүрдүүлэхийг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;**

Энэтхэг Улсын Гао хотноо 2007 оны 10 дугаар сарын 26-ны өдөр болсон Сайд нарын зөвлөлийн хоёр дахь удаагийн чуулга уулзалтын үеэр баталсан АНДХХ-ийн сайд нарын тунхаглалаар яриа хэлэлцээг тарифын бус арга хэмжээ, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээ болон хөрөнгө оруулалт зэрэг салбараар өргөжүүлэх аргачлалыг даруй батлах чиглэлийг Байнгын хороонд өгснийг **САНАЖ;**

Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (цаашид “ҮХЕХ” гэх) - ийн дүрэм, зарчмын дагуу хүлээсэн үүрэг амлалтаа **ДАХИН ТЭМДЭГЛЭЖ;**

Эдийн засгийн интеграцын тухай ҮХЕХ-ийн V зүйлийг **ҮНДЭСЛЭЖ;**

Оролцогч улс харилцан бие биедээ үйлчилгээний худалдааны хөнгөлөлт үзүүлэхээ **НОТОЛЖ;**

Үндэсний бодлогын зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор Оролцогч улсын өөрийн нутаг дэвсгэр дэх үйлчилгээний нийлүүлэлтийг зохицуулах, зохицуулалтын шинэ арга хэмжээ авах эрхийг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;**

Оролцогч улсууд худалдааг чөлөөлөхөд дөхөм болох хилийн болон хилийн бус арга хэмжээтэй холбоотой хамтын ажиллагааны бусад салбарыг эрэлхийлнэ гэж заасан АНДХХ-ийн 11 дүгээр зүйл, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай АНДХХ-ийн 26 дугаар зүйлийг тус тус **ҮНДЭСЛЭН;**

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

## **1 дүгээр зүйл Тодорхойлолт**

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

- (a) “хуулийн этгээд” гэж холбогдох хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, эсхүл бусад хэлбэрээр зохион байгуулагдсан ашгийн болон бусад төрлийн хувийн болон төрийн өмчит корпорац, итгэлцэл дээр суурилсан нэгж, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр, ганц хүний өмчлөл бүхий хуулийн этгээд, эсхүл хоршоо зэргийг хэлнэ.
- (b) “этгээд” гэж хувь хүн, эсхүл хуулийн этгээдийг хэлнэ;
- (c) хуулийн этгээдийн:
- (i) нийт гаргасан хувьцааны 50-иас дээш хувийг тухайн Оролцогч улсын этгээд эзэмшдэг бол Оролцогч улсын этгээдийн “өмчлөлтэй” гэж;
  - (ii) хэрэв тухайн этгээд нь захирлуудын дийлэнх хувийг томилох, эсхүл тэдгээрийн үйл ажиллагааг хуулийн дагуу удирдах эрх мэдэлтэй бол Оролцогч улсын этгээдийн “удирдлагад байдаг” гэж үзнэ.
- (d) “Оролцогч нөгөө улсын хуулийн этгээд” гэж:
- (i) тухайн Оролцогч улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, эсхүл бусад хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд тухайн Оролцогч улсын, эсхүл Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэрт бизнесийн дорвитой үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг; эсхүл
  - (ii) үйлчилгээ үзүүлж буй улсын нутаг дэвсгэр дээрх хуулийн этгээдээрээ дамжуулан үйлчилгээ явуулдаг бөгөөд дор дурдсан этгээдийн өмчлөл, удирдлага дор байдаг хуулийн этгээдийг хэлнэ:
    - 1. тухайн Оролцогч улсын хувь хүн; эсхүл
    - 2. (i) заалтад дурдсан Оролцогч өөр нэг улсын хуулийн этгээд.
- (e) “Оролцогч улсын хувь хүн” гэж тухайн Оролцогч улсын хуулийн дагуу тухайн улсын иргэн болох хувь хүнийг хэлнэ;
- (f) “арга хэмжээ” гэж тухайн Оролцогч улсаас авч хэрэгжүүлж буй хууль, дүрэм, журам, шийдвэр, захиргааны арга хэмжээ, эсхүл өөр бусад хэлбэрээрх аливаа арга хэмжээг хэлнэ;
- (g) “үйлчилгээний худалдаа” гэж:
- (i) Оролцогч нэг улсын нутаг дэвсгэрээс Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэрт нийлүүлсэн;
  - (ii) Оролцогч нэг улсын нутаг дэвсгэр дээр Оролцогч өөр нэг улсын үйлчилгээ хэрэглэгчид үзүүлсэн;

- (iii) Оролцогч аль нэг улсын үйлчилгээ ханган нийлүүлэгчийн Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэр дэх хуулийн этгээдээрээ дамжуулан үзүүлсэн;
  - (iv) Оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэр дээр Оролцогч аль нэг улсын үйлчилгээ ханган нийлүүлэгчийн Оролцогч улсын хувь хүнээр дамжуулан үзүүлсэн үйлчилгээг тус тус хэлнэ.
- (h) “Оролцогч улсаас авсан үйлчилгээний худалдаанд нөлөөлөх арга хэмжээ” гэж дор дурдсан үйл ажиллагаатай холбогдох арга хэмжээг хэлнэ:
- (i) үйлчилгээний худалдан авалт, төлбөр, эсхүл ашиглалт;
  - (ii) Оролцогч тухайн улсаас олон нийтэд нийтээр нь үзүүлэхийг шаарддаг үйлчилгээний нийлүүлэлттэй холбогдон үүсэх ашиглалт, эсхүл хүртээмж;
  - (iii) Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий Оролцогч аль нэг улсын этгээдийн оршин суух асуудал, хуулийн этгээдийн байршил.
- (i) “үйлчилгээ” гэдэгт Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд үзүүлдэг үйлчилгээнээс бусад салбарт хийгдэж буй аливаа үйлчилгээг хамруулна;
  - (j) “үйлчилгээ үзүүлэгч” гэж үйлчилгээ үзүүлж буй аливаа этгээд<sup>1</sup>ийг хэлнэ;
  - (k) “үйлчилгээ үзүүлэх” гэдэгт үйлчилгээний үйлдвэрлэл, түгээлт, маркетинг, борлуулалт болон хүргэлтийг хамруулна;
  - (l) “Нарийн бичгийн дарга нарын газар” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) - ын нарийн бичгийн дарга нарын газрын хэлнэ.

## **2 дугаар зүйл Хамрах хүрээ**

1. Энэхүү хэлэлцээр нь Оролцогч улсаас авсан үйлчилгээний худалдаанд нөлөөлөх арга хэмжээнд үйлчилнэ.

2. Энэхүү хэлэлцээр нь дор дурдсан зүйлд үл хамаарна:

---

<sup>1</sup> Үйлчилгээг тухайн хуулийн этгээд шууд нийлүүлээгүй, харин уг үйлчилгээг үзүүлж буй тухайн нутаг дэвсгэр дээрх салбар, эсхүл төлөөлөгчийн газар зэрэг худалдааны төлөөллийн бусад хэлбэрээр дамжуулан нийлүүлсэн тохиолдолд тус үйлчилгээг нийлүүлэгч нь ямар ч тохиолдолд энэхүү хэлэлцээрээр олгодог хөнгөлөлтийг эдэлнэ. Энэхүү хөнгөлөлтийг уг үйлчилгээг нийлүүлсэн тухайн нутаг дэвсгэр дэх этгээдэд үзүүлэх бөгөөд уг үйлчилгээг нийлүүлсэн нутаг дэвсгэрээс гадна байгаа тухайн нийлүүлэгчийн холбогдох бусад нэгжид үзүүлэхгүй.

- (a) Засгийн газрын худалдан авалт;
- (b) засгийн газрын дэмжлэгтэй зээл, баталгаа болон даатгал зэрэг татаас, эсхүл тэтгэлэг, эсхүл эдгээрийг хүлээн авах, эсхүл үргэлжлүүлэн хүлээн авахтай холбогдох аливаа нөхцөл;
- (c) арилжааны бус зорилгоор, эсхүл үйлчилгээ үзүүлэгч бусад ханган нийлүүлэгчтэй өрсөлдөх зорилгогүйгээр засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд нийлүүлж буй үйлчилгээ;
- (d) Оролцогч улсын хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх зорилго бүхий хувь хүнд нөлөөлөх арга хэмжээ;
- (e) иргэншил, байнга оршин суух, эсхүл хөдөлмөр эрхлэхтэй холбоотой арга хэмжээ.

3. Оролцогч бусад улсын хувь хүнийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх, эсхүл түр оршин суухтай нь холбогдуулан хилийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хувь хүний хил нэвтрэх хөдөлгөөнийг зохицуулах зэрэг арга хэмжээг Оролцогч улсын зүгээс авахад энэхүү хэлэлцээрийн аль ч заалт саад учруулахгүй. Гэхдээ ийм арга хэмжээг Оролцогч бусад улсын энэхүү хэлэлцээр, эсхүл дараа дараачийн яриа хэлэлцээний дагуу авч хэрэгжүүлэх тусгай үүрэг амлалтаас хүртэх аливаа давуу эрх, үр ашгийг бууруулах, цуцлах байдлаар хэрэглэхгүй.<sup>2</sup>

### **3 дугаар зүйл Зорилго**

Оролцогч улс энэхүү хэлэлцээрийн дагуу дараах зорилгыг хэрэгжүүлнэ:

- (a) өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Оролцогч улс хооронд үйлчилгээний салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйлчилгээ ханган нийлүүлэгчдийнхээ Оролцогч улс хоорондын болон гаднах үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлтийн чадавхийг төрөлжүүлэх;
- (b) Оролцогч улс хооронд үйлчилгээний худалдааг хөнгөвчлөх зорилгоор хязгаарлалтыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах;
- (c) чөлөөлөлтийн хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах замаар үйлчилгээний худалдааг ҮХЕХ-ээс илүү чөлөөлөх.

### **4 дүгээр зүйл Хамтын ажиллагааны салбар**

---

<sup>2</sup> Оролцогч зарим улсын хувь хүнээс шаардаагүй боловч Оролцогч тодорхой улсын хувь хүнд тавьж буй визийн шаардлагыг тусгай үүрэг амлалтаас хүртэх аливаа давуу эрх, үр ашгийг бууруулсан, цуцалсан гэж үзэхгүй.

1. Оролцогч бүх улс энэхүү хэлэлцээрийн дагуу хамтын ажиллагааны үйл ажиллагаанд оролцоно.

2. Оролцогч улс үйлчилгээний салбарт хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны хүч чармайлтыг нэмэгдүүлэн, бэхжүүлж, уг хамтын ажиллагааны хүрээнд хамрагдаагүй салбарын хамтын ажиллагааг дараах замаар хөгжүүлнэ. Үүнд:

(a) дэд бүтцийн байгууламжийг байгуулах, эсхүл сайжруулах;

(b) хамтарсан үйлдвэрлэл, маркетинг болон худалдан авалтын үйл ажиллагаа;

(c) судалгаа, хөгжүүлэлт; болон

(d) мэдээлэл солилцоо;

3. Оролцогч улс хамтын ажиллагааны салбараа тодорхойлж, хамтын ажиллагааны шинж чанар, хамрах хүрээг нарийвчлан заасан үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр, харилцан ойлголцлын баримт бичгийг боловсруулна.

### **5 дугаар зүйл Худалдааг чөлөөлөх**

3 дугаар зүйлийн 3(c) хэсгийн дагуу, Оролцогч улс үйлчилгээний худалдааг олон тооны салбарт дараах байдлаар чөлөөлнө:

(a) Оролцогч улс хооронд хэрэгжиж буй ялгавартай арга хэмжээ, зах зээлд нэвтрэх хязгаарлалтыг аажмаар бууруулах;

(b) шинээр ялгавартай арга хэмжээ, зах зээлд нэвтрэх хязгаарлалт нэвтрүүлэхээс татгалзах.

### **6 дугаар зүйл Тусгайлан анхаарах**

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу гаргаж өгөх бүх тусгай үүрэг амлалтын хуваарь, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлэх, хэрэгжүүлэх асуудлаар Нэн буурай хөгжилтэй Оролцогч улсад уян хатан хандана. Оролцогч улс өөрийн тусгай үүрэг, амлалтын хуваарь, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөгөөрөө эдгээр улсад зориулан тусгай хөнгөлөлт олгох асуудлыг боломжтой үедээ судлан үзнэ.

2. Оролцогч бусад улстай үйлчилгээний худалдааны харилцаагаа өргөжүүлэхэд чиглэсэн техникийн туслалцаа авах, хамтын ажиллагааны тохиролцоо хийх, энэхүү хэлэлцээрийн бодит үр ашгийг хүртэх тухай Нэн буурай хөгжилтэй Оролцогч улсаас гаргасан хүсэлтийг Оролцогч улс тусгайлан анхаарна.

3. Энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн дагуу Шри-Ланка Улсыг мөн адил тусгайлан анхаарна.

## **7 дугаар зүйл**

### **Тусгай үүрэг, амлалтын талаарх яриа хэлэлцээ**

1. Оролцогч улс үйлчилгээний тодорхой салбарын худалдаанд нөлөөлөх арга хэмжээний талаар яриа хэлэлцээ хийнэ. Хэрэв Оролцогч улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улс бол ийм яриа хэлэлцээ нь ҮХЕХ-ийн Оролцогч улс бүрийн тусгай үүрэг амлалтын хуваарьт тусгагдсан үүрэг амлалтаас илүү үүрэг амлалтыг өгөхөд чиглэнэ. Тус яриа хэлэлцээний үр дүнг Оролцогч улс бүрийн тусгай үүрэг амлалтын хуваарьт тусгана. Уг хуваарийг энэхүү хэлэлцээрт хавсаргах бөгөөд хэлэлцээрийн салшгүй хэсэг гэж үзнэ.

2. Өөрөөр тохиролцоогүй бол 6.1 дэх хэсгийг харгалзан үзсэний үндсэн дээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай үүрэг амлалтыг Нэн тааламжтай үндэстний нөхцөл (НТҮН)-ийн дагуу Оролцогч бүх улсад өгнө.

3. Оролцогч улс ҮХЕХ-ийн XVI-XVIII болон XX зүйлийг тусгай үүрэг амлалт өгөх зорилгоор хэрэглэнэ.

## **8 дугаар зүйл**

### **Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээр**

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, Оролцогч улс 13 дугаар зүйлийн дагуу хэлэлцээрийг хянасны үндсэн дээр хэлэлцэн тохиролцсон аливаа тохиролцоог харгалзан, тухайн Оролцогч улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн мөн эсэхээс үл хамаарч, үйлчилгээний худалдаатай холбоотой болон түүнд үйлчлэх Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийг даган мөрдөхөө үүгээр дахин нотолж, хүлээн зөвшөөрч байна.

## **9 дүгээр зүйл**

### **Үл хамаарах нөхцөл**

Энэхүү хэлэлцээр болон түүнээс үүдэн гарах үйлчилгээний худалдаатай холбоотой аливаа тохиролцоо, хэлэлцээр, харилцан ойлголцлын баримт бичигт АНДХХ-ийн 35 дугаар зүйл үйлчилнэ.

## **10 дугаар зүйл**

### **Маргаан шийдвэрлэх**

Энэхүү хэлэлцээрийн дагуу маргаан шийдвэрлэх тусгай механизм байгуулаагүй бол АНДХХ-ийн 21 дүгээр зүйл энэхүү хэлэлцээрт үйлчилнэ.

## **11 дүгээр зүйл**

### **Давуу эрх олгохоос татгалзах**

Урьдчилан мэдэгдэл хүргүүлсэн, зөвлөлдсөн эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр, Оролцогч улс дараах тохиолдолд энэхүү хэлэлцээрийн дагуу давуу эрх олгохоос татгалзаж болно:

- (a) үйлчилгээг энэхүү хэлэлцээрийн Оролцогч бус улсын нутаг дэвсгэрээс, эсхүл Оролцогч бус улсын нутаг дэвсгэрт нийлүүлсэн болохыг тогтоосон бол тухайн үйлчилгээнд;
- (b) Далайн тээврийн үйлчилгээг дор дурдсанаар нийлүүлсэн болохыг тогтоосон бол:
  - (i) Оролцогч бус улсын хуулийн дагуу бүртгэлтэй усан онгоцоор; болон
  - (ii) Оролцогч бус улсын этгээдийн ажиллуулж буй, эсхүл бүхлээр нь, эсхүл зарим хэсгийг нь ашиглаж буй онгоцоор;эсхүл тухайн улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлдэг өөр улсад бүртгэлтэй онгоцоор нийлүүлсэн болох нь тогтоогдсон бол.
- (c) Оролцогч өөр нэг улсын үйлчилгээ ханган нийлүүлэгчид, дараах тохиолдолд:
  - (i) үйлчилгээ ханган нийлүүлэгч хувь хүн нь Оролцогч бусад улсын иргэн биш болохыг тогтоосон бол;
  - (ii) үйлчилгээ ханган нийлүүлэгч хуулийн этгээд нь энэхүү хэлэлцээрээр тодорхойлсон Оролцогч өөр нэг улсын хуулийн этгээд биш болохыг тогтоосон бол.

## **12 дугаар зүйл**

### **Нэмэлт хэлэлцээр болон тохиролцоо**

Энэхүү хэлэлцээр болон бусад хэлэлцээр, тохиролцоо, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн дараа дараачийн яриа хэлэлцээнээс үүдэн гарсан тодорхой үүрэг амлалтын хуваарь, харилцан ойлголцлын баримт бичиг нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

## **13 дугаар зүйл**

### **Бусад хэлэлцээр**

1. Энэхүү хэлэлцээр, эсхүл хэлэлцээрийн дагуу авсан аливаа арга хэмжээ нь Оролцогч улсын нэгдэн орсон, хүчин төгөлдөр хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.
2. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт тус хэлэлцээрийн зарчим, зорилго, нөхцөлтэй үл зөрчилдөх өөр хэлэлцээр байгуулах Оролцогч улсын эрхийг хөндөхгүй.
3. Оролцогч улс энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан даруй үйлчилгээний худалдаатай холбоотой, эсхүл нөлөөлөхүйц гарын үсэг зурсан бусад хэлэлцээрийн талаар Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.



## **14 дүгээр зүйл**

### **Дотоод үйл ажиллагааны журам**

1. Сайд нарын зөвлөл энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хоёр жил тутамд хянана.

2. Байнгын хороо энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, удирдах, яриа хэлэлцээг зохион байгуулах зэргээр, хэлэлцээрийн хэтийн зорилгыг тодорхойлох, үйл ажиллагааг нь хөнгөвчлөх чиг үүрэгтэй.

3. Байнгын хороо нь энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор, үйлчилгээний худалдааны тодорхой салбар болон дэд салбарын ахлах ажилтан, шинжээчээс бүрдсэн Үйлчилгээний ажлын хэсгийг байгуулна.

4. Нарийн бичгийн дарга нарын газар нь Сайд нарын зөвлөл, Байнгын хороо, Үйлчилгээний ажлын хэсэгт энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, удирдан, зохион байгуулах зэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэргээр туслалцаа үзүүлнэ.

## **15 дугаар зүйл**

### **Нэмэлт, өөрчлөлт**

1. Энэ зүйлийн 2 дугаар хэсгийг харгалзан үзсэний үндсэн дээр, Оролцогч бүх улсын зөвшөөрлийн дагуу энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Оролцогч бүх улс хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

2. Хуваарьт тусгасан аливаа үүрэг амлалтыг өөрчлөх, буцаан авах асуудлыг ҮХЕХ-ийн 21 дүгээр зүйлийн дагуу *mutatis mutandis* (зохих өөрчлөлттэйгөөр) зарчмын дагуу зохицуулна. Үйлчилгээний худалдааны зөвлөл гэснийг АНДХХ-ийн Байнгын хороо гэж үзнэ. ХХI зүйлийн 3 болон 4 дүгээр хэсэгт заасан арбитр гэснийг маргааныг Оролцогч улсын гуравны хоёрын зөвшөөрлөөр шийдвэрлэж болох АНДХХ-ийн Байнгын хороо гэж үзнэ.

## **16 дугаар зүйл**

### **Хүлээн зөвшөөрөх**

1. Үйлчилгээ ханган нийлүүлэгчид эрх, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох стандарт, шалгуурыг хангах зорилгоор, Оролцогч улс Оролцогч өөр нэг улсад эзэмшсэн боловсрол, эсхүл туршлага, хангасан шалгуур, эсхүл олгосон тусгай зөвшөөрөл, гэрчилгээг хүлээн зөвшөөрч болно.

2. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа, Оролцогч улсын зохицуулалт бүхий үйлчилгээний аливаа салбарт Оролцогч өөр нэг улсаас бичгээр хүсэлт гаргавал Оролцогч улс зохих тохиолдолд өөрийн холбогдох мэргэжлийн байгууллагыг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, түр зөвшөөрөл,

гэрчилгээ олгоход мөрдөх харилцан хүлээн зөвшөөрөх боломж бүхий стандарт, шалгуурыг боловсруулах яриа хэлэлцээ хийхийг дэмжинэ.

### **17 дугаар зүйл Харилцах этгээд**

1. Хэлэлцээрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг солилцох зэрэг энэхүү хэлэлцээрийн үйлчлэх хүрээнд хамаарах аливаа асуудлаар Оролцогч улс хооронд харилцах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор харилцах этгээдийг томилно.

2. Хүсэлтийг хүлээн авч буй Оролцогч талын харилцах этгээд нь Оролцогч аль нэг талын хүсэлтийн дагуу тухайн асуудлыг хариуцсан байгууллага, эсхүл албан тушаалтныг тогтоон, хүсэлт гаргасан Оролцогч талтай харилцах үйл ажиллагааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлнэ.

### **18 дугаар зүйл Төгсгөлийн заалт**

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд үүссэн боловч энэхүү хэлэлцээрээр тусгайлан зохицуулаагүй аливаа асуудалд ҮХЕХ-ийн нэр томъёо, тодорхойлолт болон бусад зохицуулалтыг хэрэглэнэ.

2. Энэхүү хэлэлцээр нь хэлэлцээрт гарын үсэг зурсан бүх Засгийн газар хэлэлцээрийг соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулснаар хүчин төгөлдөр болно. АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар батламж жуух бичгийн баталгаат хуулбарыг Оролцогч улс бүрд нэн даруй хүргүүлнэ. Хэлэлцээрт гарын үсэг зурсан Засгийн газар энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зургаан сарын дотор соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ хадгалуулна.

3. АНДХХ-ийн 11 болон 26 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээр нь АНДХХ-ийн Хавсралт III-B хэсэг болох бөгөөд хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

**ДЭЭРХИЙГ НОТОЛЖ**, дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид АНДХХ-ийн Оролцогч улс хооронд үйлчилгээний худалдааг идэвхжүүлэх, чөлөөлөх тухай ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг хоёр мянга арван нэгэн оны наймдугаар сарын хорин дөрөвний өдөр англи хэлээр найман хувь үйлдэв, эх тус бүр нь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ БАНГЛАДЕШ АРД УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:  
(гарын үсэг )  
ХУДАЛДААНЫ САЙД МУХАМЕД ФАРУК ХАН

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:  
(гарын үсэг )  
ХУДАЛДААНЫ ДЭД САЙД И ШАУЖУН

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:  
(гарын үсэг )  
ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД ЖОТИРАДИТЯА М.СКИНДИА

БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:  
(гарын үсэг )  
АЖ ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД НАМ ВИЯКЭТ

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:  
(гарын үсэг )  
САНХҮҮ, СТРАТЕГИЙН НЭГДҮГЭЭР ДЭД САЙД ЖУН-ЁН ИМ

БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ШРИ-ЛАНКА УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:  
(гарын үсэг )  
ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД РИШАД БАТИЮДИЙН